

ОЮУ ЧИХТ ХАН ХӨВГҮҮНИЙ ТУУЖ ЗОХИОЛЫН ЗОХИОГЧИЙН ТУХАЙ
(*Gegeen toli orošiboi* зохиол, түүний бичлэгийн хэв шинжинд тулгуурлав.)

А.Мөнхцэцэг*

Төвдөөс дэлгэрсэн бурхны шашны дахин дэлгэрэлтийн үе болох XVII-XVIII зууны үеэс бурхны шашны сэдэвт зохиолууд хүчтэй нэвтрэн дэлгэрч байсны нэг нь баруун Монголд болон халхын зарим нутгуудаар *Оюу чихт хан хөвгүүний тууж*¹, *Үнэхээр төрөлхт сайн хааны тууж* нэртэй бичмэл хэлбэрээр дэлгэрсэн хойт эх-дагавар хүүхдийн сэдэвт нэгэн зохиол байдаг. Энэхүү зохиолыг чухам хэн хэдий үед орчуулсан аль эсвэл хэн нэгэн монгол хүн зохиосон уу гэдэг тодорхойгүй байгаа хэдий ч XVII-XVIII зууны үеийн бурхны шашны уран зохиолын хүрээнд авч үзэх нь зүйтэй юм. Ер нь “XVII-XVIII зууны үеийн хүүрнэл зохиол нь гол төлөв Энэтхэг, Төвдийн үлгэр домгийн шинж чанартай зохиолуудыг зохиомжлон орчуулсан буюу түүнээс сэдэвлэн монгол ахуй нөхцөлдөө нийцүүлэн найруулан зохиосон шинжтэй байдаг юм. Ийм маягийн зохиолын зарим нэг нь монгол оронд шарын шашин хүчтэй дэлгэрэх үед Энэтхэг, Төвд зохиолыг дуриалган зориуд найруулан бичсэн тодорхой баримт бас ажиглагдаж байна.”² Энэ санаанд тулгуурлан монгол газар оронд зохиосон байж болохуйц нэгэн зохиол бол *ОЧХХ* зохиол бөгөөд уг зохиолтой утга агуулга хийгээд бичвэрийн найруулгын хэв маягийн хувьд төсөөтэй нэгэн зохиолтой харьцуулалт хийсний үндсэн дээр монгол газар оронд, монгол хүн зохиосон байж болох юм гэсэн таамаглалыг дэвшүүлж байгаа билээ.

**1. *Gegeen toli orošiboi*³ нэрт зохиолын агуулга хийгээд
зохиогч, орчуулагчийг тодруулах нь**

Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662)-ын тууж *Сарны гэрэл*⁴ зохиол дахь Зая бандида хийгээд түүний шавь нарын орчуулсан бүтээлүүдийн жагсаалтанд *Gegeen toli* хэмээх зохиол багтсан байдаг.

54.3смх18.5 см хэмжээтэй давхарлаж наасан зузаан муутуу цаасан дээр 31-34 мөрөнд бичсэн нийт 134 хуудас 267 тал бүхий хар болон улаан шунхан хулсан үзгээр тод бичгээр хичээнгүй бичсэн энэхүү зохиол нь Монгол Улсын Үндэсний Номын сангийн тод үсгийн хөмрөгт 8434/96 дугаартай хадгалагдаж байна. байна.

*Монгол Улсын Их Сургууль

1. Цаашид ОЧХХ гэж товчлов. Оуу čikitü хаан köböüni toüji orošiboi (Тод үсгээр). ХИС-ын МХУЗ-ын тэнхмийн харьяа “Монголчуудын бичиг үсгийн дурсгалын сан”-д Тоб №95.; Ünekeer törölkütü sayin xāni toüji orušibui. /Тод үсгээр./ УҮННСангийн тод үсгийн хөмрөгт 8308/96 401 дугаартай. ; Üneker törülkitü sayin qaγan-u tuγuji orušibui. /Монгол бичгээр./ УҮННСангийн монгол бичгийн хөмрөгт 7963/96 89 v-856 дугаартай.; Оюу чихт хан хөвгүүний тууж тэргүүтэн монголын сонгодог уран зохиолын хэдэн дурсгал. Эрхэлсэн Д. Ганболд, 2005.

2. Д. Цэрэнсодном, “XVII-XVIII зууны үеийн уран зохиол” Монголын уран зохиолы судлалын шинэ хандлага. Улаанбаатар. 2008: 63

3. Цаашид ГТО гэж товчлов. Gegeen toli orošiboi (Тод үсгээр). УҮННСангийн тод үсгийн сан хөмрөг.

4. Rabjamba Caγ-a bandita-yin tuγuji saraγ-u gerel kemekü ene metü bolai /Монгол бичгээр/. CSM. T-V, Fasc.2. Улаанбаатар. 1959.; Заябандида, Равжамба. Сарны гэрэл оршвой. Улаанбаатар. 1967.

Зохиолын ерөнхий агуулга нь Энэтхэг, Хятад, Монгол, Төвдийн номын хаадын түүхийн үе, хийгээд хутагт Нүдээр үзэгч бодьсадва (*Skt. Avalokiteśvara; Tib. Sryan gas gzigs*) “хязгаар хөшүүн” Цастын орныг номхтгосон тухай цадиг түүхүүдийг багтаасан 16 бүлэг бүхий хоёр тусдаа зохиолын эмхтгэл бөгөөд Нүдээр үзэгчийн магтаал дуулал, Номын хаадын түүхийг бичихэд ашигласан зохиолуудыг тусгайлан дурдснаас гадна хэн зохиосон хийгээд монголчлон орчуулсан (найруулсан) тухай өгүүлсэн төгсгөлийн үгтэй нилээн том хэмжээний зохиолд багтах юм. Зохиолын бүлэг тус бүрийн гарчгийг нь үзвэл

1. Урьд галав ямар тогтсоноос Энэтхэгийн номын хаан улам өөд болсон хийгээд багш Шакьяамуни ертөнцөд өөд болон дээд ном дэлгэрсэн бүлэг.
2. Шакьяамуни бурхны гурван бие босгохуй хийгээд сайтар амилан оршуулан үйлдсэн бүлэг.
3. Хятад, Монголын оронд дээд ном дэлгэрсэн хийгээд хааны үе ямар өөд болсныг үзүүлсэн бүлэг.
4. Хутагт бадмаас хувилсан хийгээд зургаан үсгийн ач тус үзүүлсэн бүлэг.
5. Хутагт Нүдээр үзэгч эрхэт Цастын амьтан нугуудыг боловсрон гэтэлгэхүйд зохиосон урьд бүлэг.
6. Морины хаанд хувиран амьтны тус үйлдсэн бүлэг.
7. Эзэн хийгээд албат болон Төвдийн хүний үндэслэл сарбэчин хийгээд хадын эм мангасаас болсон бүлэг.
8. Төвдийн хааны язгуур үе урьд ямар өөд болсныг үзүүлсэн бүлэг.
9. Хутагт Нүдээр үзэгчийн биеэс дөрвөн гэрэл цацарснаас Номын хааны бие хувилсан бүлэг.
10. Түшмэл Томи самбудда (*Mtonmi Sambhuda*) Энэтхэгээс үсэг орчуулсан хийгээд хаан арван буяныг зарчимласан бүлэг.
11. Хааны Ядам бурхан Энэтхэг хийгээд Балбын орноос залсан бүлэг.
12. Балба төрхт Цагаан дара-г залсан бүлэг.
13. Хятад Ногоон дара-г залсан бүлэг.
14. Хязгаар номхтгох хийгээд бас номхтгох сүм хийгээд их Зуу хийгээд бага Зуу нугуудыг сайтар босгосон бүлэг.
15. Хоёр зуун хязгаар номхтгох хийгээд бас номхтгох бурхны сүм тэргүүтнийг сайтар дуусч сайтар амилан оршуулсан бүлэг.
16. Сан дарсан хийгээд Төвдийн албат нугуудыг номд зохиосон бүлэг.
17. Хутагт эрхэн Нүдээр үзэгч бодьсадвагийн магтаал, залбирал
18. Төгсгөлийн үг

Уг зохиолын төгсгөлийн үгийг дэлгэрэнгүй үзүүлбэл: “*arban zügiyin xamuq burxadiyin nigöülesküi amitani itegel Yeke nigöülesüqçi tere : aldaršiqsan Töböd oron-du sarbečin kigeed eme raqxa-beer : aryalan Töböd uluši uduridun üyiledüqsen kigeed & narmai yeke Töbödi nomoyodxon üyiledküyin tula : naran metü šudurγu sürtei Nomiyin xaān-du xubilji : nada metü ухаān-yeēr Töböd uluši erkedü xuraān : nasu ürgüljide arban buyani zasaqtu zoqoāboi & xamugiyin itegel xoyor Zoūgi xoyor daqini zalaji : xara zügiyin mangγus jidküri nomoyodxon üyiledçi : xamuqtu tügeemel xoyor Zoū Samye-yi terigöüteni bariqsan kigeed : xaādiyin üye nomloqson Todorxoi toil kemeekü öüni : töröl Mongγul bolboči Töbödtü öedö bolun Töbödiyin nomdu erke orcüülün üyiledçi töröqsen orondu xarin <...ridi> mongγolčilon törö šajini delgereülün üyiledüqçi erdeni zarligiyin γurban aci tögüsüqsen boqdo Za ya bandida erkin töüni zarligiyin arašaān-yeēr amiduraqsan ecüs šabi eke boluqsan amitan*

*noγōıdtu tusa bolumu kemeēn : ende dalai metü şajini nemüridü soqbun Sayin erdeni orčiülbai*⁷
[134a4-26] гэжээ.

Эндээс үзвэл Их нигүүлсэгч хутагт Нүдээр үзэгч Төвд оронд сармагчин болон эм шулмасаар аргалан Төвд улсыг удирдан, Төвдийг номхтгохын тул Шударга төлгөн номын хаанд хувилан, хүмүүний ухаанаар тэднийг гэгээрүүлсэн болон хоёр Зууг хэрхэн бүтээсэн, Цагаан дара, Ногоон дара-г хэрхэн залсан, хар зүгийн мангас чөтгөрийг дарсан болон хоёр Зууг Самьяа хийд(*Bsam yas*)⁵-эд барьсан тухай өгүүлсэн Нүдээр үзэгч бодьсадвагийн цадиг түүх бүхий нэг зохиол⁶, Энэтхэг, Хятад, Монгол, Төвдийн хаадын үе номлосон *Todorxoi toli*⁷ хэмээх өөр нэгэн түүхийн зохиол байгаа ба уг зохиол доторхи Номын хаадын түүхийн үеийг өгүүлсэн *Todorxой толь* зохиолыг *tenggeri toyin Coq erdeni duraduqsan tala-du : oçir bariqçi Buyan ilayūqsan belge : xaγacaliyin endöürel tebçiji ... ere şorui glü jil-dü Coqtu Samyayin yeke süme-dü sayitur zoqoāqson* [133a28; 133b29] гэсэн нь *Buyan ilayūqsan belge* (*Tib. Bsod-nams Rgyal-mtshan*) сав ертөнцийн орон хэрхэн үүссэн болон Монгол, Хятад, Төвд, Энэтхэгийн орон хаана орших хийгээд тэр улсын хаадын язгуур угсааг тоочсон байгаагаас гадна Энэтхэгийн оронд Ялгуун төгсөн үлсэн бурхан арван хоёр зохионгуйг хэрхэн үзүүлсэн тухай түүхийг бусад ном зохиолуудыг ашиглаж эр луу жилд зохиожээ. Тэрхүү “эр луу жил”-ийг хэдэн он болохыг барагцаалан үзвэл, зохиолын доторхи хаадын түүхэн он цагийн хэлхээст байгаа Монголын сүүлийн хаан нь “*Tömör хаān xan oron döçin nayıman jil barin:... tegeēd xan oro Rgya-dai nere-tü хаān-du aldabai kemeēldemüi*” [15b9-12] гэсэн нь Юан гүрний сүүлчийн хаан болох Тогоон төмөр хаан (1333-1370)-ыг хэлсэн бөгөөд “1368 онд Жу Юан Жанаар толгойлуулсан улаан алчууртнууд Юан улсыг мөхөөж Мин улсыг байгуулсан”⁸ тухай өгүүлсэн байна. Тиймээс зохиолд дурдагдаж байгаа “эр луу жил” нь 1388 онд эсвэл 1448 он гэсэн хоёр он цагийн аль нэг нь таарах юм. Тиймээс Энэтхэг, Хятад, Монгол, Төвдийн номын хаадын түүхийн *Todorxой толь* нэрт зохиолыг Буян ялгуусан бэлгэ буюу Содномжалцан *Samya süme* (хийд)-д байхдаа XIV зууны сүүлийн 1388 он юм уу, XV зууны 1448 оны эр луу жилд зохиосон ажээ.⁹

Харин XVII зууны дунд үед Ойрадын Зая бандида Төвдөөс гарсан үеэс хойш буюу Далай ламын “Миний төлөө монгол хэлтэнд гарч шажин хийгээд амьтанд ном орчуулан туслан үйлд” гэсэн захиасыг гүйцэлдүүлэхээр “долоон хошуу дөрвөн Ойрадад” шажин дэлгэрүүлэхээр ном судар орчуулах тодорхой зорилготой байсан үе гэгддэг 1638-1650¹⁰ оны үеэр бурхны шашны тэр дундаа хутагт Нүдээр үзэгчийн цадиг түүх, магтаал залбиралыг олноор орчуулж байснаас “эцэс шавь” сойвон Сайн эрдэнэ (Ринченсамбуу) буюу Раднаабадраа нь дээр өгүүлсэн Буян ялгуусан бэлгэ буюу Содномжалцаны Номын хаадын түүхийг товчлон өгүүлсэн *Todorxой*

5. Ертөнцийн төв, Сүмбэр уулыг бэлгэдэж, мандал хэлбэртэй баригдсан хийд. <http://gohistoric.com/places/samye-monastery>

6. Улсын нийтийн номын сангийн монгол бичгийн хөмрөгт *Gegen toli orşibai* нэрт нэгэн зохиол хадгалагдаж байна. Энэ зохиол нь төгсгөлийн үг байхгүй тул хэн, хэдийд орчуулсан тухай мэдээлэл үгүй юм. Харин энэ нь уг цадигийн 2, 4, 5, 9-15 бүлгүүдийн хувилбар орчуулга байна. Бидний таамаглаж байгаагаар Л.Хүрэлбаатар багшийн бичсэн Алтангэрэл увшийн орчуулсан “Алдаршсан буянт” буюу Содномдагвын зохиосон Соронзонгомбо хааны гэгээн толь хэмээх 27 бүлэгтэй түүхийн зохиол” нь дээрхи зохиол байж болох юм. Л. Хүрэлбаатар, 1995: 49-69-ээс иш татан харьцуулав.

7. Номын хаан нугуудыг товчлон хураасан тууж Тодорхой толь хэмээх нэр нь төгсгөлийн үгэнд гурван удаа давтагдаж байгаа юм. [133a,b; 134a]

8. http://mn.wikipedia.org/wiki/Тогоонтөмөр_хаан

9. Сажа Дондов тойны орчуулсан Содномжалцангийн Гэгээн толь хэмээх зохиол нь дээрхи Тодорхой толь нэрт зохиол байж болох юм. Л. Хүрэлбаатар, “XV-XVI зууны үеийн орчуулгын зохиол” Монгол орчуулгын товчоон (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудалд). Улаанбаатар хот. 1995: 49-69; Тод бичиг болон Зая бандида Намхайжамц судлалын асуудал *Bibliotheca Oiratica*-XIII. Улаанбаатар. 2009: 95-105-аас иш татан харьцуулав.

10. Л. Хүрэлбаатар, “XV-XVI зууны үеийн орчуулгын зохиол” Монгол орчуулгын товчоон (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудалд). Улаанбаатар хот. 1995: 49-69; Тод бичиг болон Зая бандида Намхайжамц судлалын асуудал *Bibliotheca Oiratica*-XIII. Улаанбаатар. 2009: 95-105.

толь зохиолыг хутагт Нүдээр үзэгч Төвдийн орны *номхтголын* эзэн болоод Шударга төлгөн хаан болон *гурван цагийн мянган бурхад* ч номхтгож чадахгүй байсан хязгаар хөшүүн Цастын хамаг амьтныг бурхны шашинд оруулсан түүхийг Нүдээр үзэгч бодьсадва буюу Шударга төлгөн хааны цадиг түүхээр баяжуулан эмхтгээд *ГТО* нэрт 16 бүлэг¹¹ болгон бүтээсэн ажээ. Энэ тухайгаа “*үл зохин, үл харих нугуудыг найраxуйн тул өчүүхэн орхисон хийгээд үг нэмсэн ч буй. Үг утга шинжилж өршөөн ясан (засан) үйлд. Огоот үлгэр тэднийг илүү дутуу болсон болохул хүлцэн соёрх*” хэмээн төсгөлд нь тэмдэглэсэн байдаг.

2. “Үнэхээр төрөлхт сайн хааны Малаяагийн жаргалант орон” нь “Хязгаар хөшүүн Цастын орон” болох хийгээд Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын зохиогчийн тухай

ОЧХХ зохиол нь Нүдээр үзэгч бодьсадвагийн урьд дүрийн цадиг үлгэрийг Ялгуун төгсөн үлсэн бурхан зургаан мянган бодьсадва нарт номлож, Нүдээр үзэгч бодьсаван Энэтхэгийн төв дундад орны Үнэхээр төрөлхт сайн хааны Оюу чихт хан хөвгүүн болон эцэг хийгээд хамаг амьтныг шулмасын зовлонгоос салгаж байгаа тухай хойт эхдээ хөөгдсөн эгч дүү хоёрын явах замын саад зовлонг хэрхэн туулан давж, Шанхалагийн оронд очиж, Оюу чихт хан хөвгүүн тэр орны эзэн Цог төгссөн Цагаан хутагтын гэгээний дүү Сэтгэлийн чимэг хэмээх охинтой ханилан, Эрдэнэ авхай цэцэг хэмээх эгч нь Саналын чимэг хэмээх дүүтэй нь ханилаад, Оюу чихт хан хөвгүүн хорин насанд хүрэх цагтаа өөрийн эцгийг шулмас хатнаас аварч, өөрийн ард иргэдийг Шанхалагийн оронд аваачиж тэнд жаргаж байгаа тухай цадиг юм.

Зохиолын үйл явдлын тайлал хэсэг болох Оюу чихт хан хөвгүүн өөрийн эцгийг аварч Албинга нэрт таван хорт сэтгэлт шулмас хатныг алаад, “*түүний арьсыг өвчин тэлж их алтан дэлхийд хувилган, махы нь цогцлоон Сүмэр уул болгон, цусы нь дөрвөн их далай*” болгодог бөгөөд “*Урьд Үнэхээр төрөлхт хааны баясгалангийн ой цэцэрлэг өдгөө манагар шумну эмийн хорт амь таслагч тэрсийн орны нүгэлт цэцэрлэг мөн*” болсон тул ард иргэдээ Шанхалагийн улс руу хамтдаа явахыг уриалснаар Буяны дохио мэдэгч хэмээх түшмэл тэргүүлэн гурван мянган түшмэл, таван бум нөхөдтэй ирдэг. Дээрхи ишлэл санаа нь *ГТО* зохиолын 14-р бүлэгт Ногоон дара Хязгаар хөшүүн цастын орныг үзээд “*эм мангас гэдрэг хэвтсэн дүртэйд мэдэн, Сүн далай үүнийг эм мангасын зүрхний цусанд мэдэн, гурван уулыг зүрхний ясанд мэдэн, энэ газар эм мангасын зүрхэн дээр тогтсонд мэдэн тэр шулмас эмийн орныг бурхны сүм барих газар болгосон*”¹² тухай өгүүлсэн хэсэгтэй яг таарч байгаа нь их сонирхолтой юм. *ГТО* зохиолд дүрслэгдсэн Хязгаар хөшүүн Цастын тэр орон нь урьд Үнэхээр төрөлхт сайн хаан шулам хатантай нөхцсөнөөр “Шулмасын нүгэлт цэцэрлэг” болсон тэр Малаяагийн жаргалант ой байж болох нь үйл явдлын цуваа холбоосоор тохирч байгаа юм. Энэхүү хоёр зохиолд дүрслэгдсэн “Шулмасын нүгэлт цэцэрлэг” болон “Хязгаар хөшүүн Цаст орон” нь *шулмасын арьсыг өвчин газар дэлхийд тэлэн хувилгасан буюу эм мангас гэдрэг хэвтсэн: махы нь цогцлоон Сүмэр уул болгосон буюу гурван уулыг зүрхний ясанд мэдэн: цусы нь дөрвөн их далай болгосон буюу Сүн далай үүнийг эм мангасын зүрхний цусанд мэдсэн* нь нэг л ижил дүрслэл байна. Энэхүү хоёр зохиолын цуваа холбоос нь, Нүдээр үзэгч бодьсадва урьд төрөлдөө Оюу чихт хан хөвгүүнд хувилан Үнэхээр төрөлхт сайн хааны хөвүүн болсон бөгөөд эцэг нь Албинга нэрт шулам хатантай нөхцсөнөөр хамаг амьтан зовлонгийн далайд унахад Оюу чихт хан хөвгүүн шулмас хатныг устгаж, ард олныг дагуулан Шанхалагийн оронд очсон тул урьдны Үнэхээр

11. УҮННСангийн монгол бичгийн хөмрөгт Gegen toil oršibai зохиолд Морины хаанд хувилан амьтны тус үйлдсэн 6-р бүлэг болон Төвдийн хүний үндэслэл сарбэчин хийгээд хадын эм мангасаас болсон 7-р бүлэг байхгүй байгаа тул Раднаабадраа нэмж орчуулсан байж болох юм.

12. “Энэ Цастын газарт аварга эм гэдрэг хэвтсэн газар байна. Энэ нуур аварга эмийн цус байна. Энэ гурван уул зүрхний яс байна. Энэ нуурыг бүтээж дээрийг сүм барилтай буюу. Эд муу заяатны хаалга буюу.” УҮННСангийн монгол бичгийн хөмрөгт байгаа Gegen toil oršibai, 43b12-26.

төрөлхт сайн хааны Малаяагийн жаргалант орон “*Шулмасын нүгэлт цэцэрлэг*” болсон бөгөөд орхигдсон тэрхүү Хязгаар хөшүүн орныг Нүдээр үзэгч бодьсадва зургаан мянган бодьсадва нарт амлалт өгөн тэр орны “*номхтгох бэрх амьтан нугуудыг тонилсон бодид зохион чадах хийгээд чөтгөр мангас тэргүүтэн тэд бүгдийн эцэг эх мэт*” болохоор хойт төрөлдөө Шударга төлгөн хаан болон эргэн ирсэн холбоост цадиг байна гэж үзэж байна. Цаашилбал, ОЧХХ-д “*зүүн зүгт Шанхалын орон урьд хязгаар хөшүүн мөн. Өдгөө Цагаан хутагтын их буяны үрээс бүтсэн эрдмийн цогцод тэр орны улс өдгөө мангар шүтсэнээр сайваар номын баясгалангийн хуримт цэцэрлэг мөн*” гэснээс үзвэл, урьд жаргалангийн орон байсан Үнэхээр төрөлхт сайн хааны Малаяагийн цэцэрлэг нь ГТО дахь “*Хязгаар хөшүүн орон*” болсон гэдгийг илтгэж байна. Тэрчлэн “*хутагт Нүдээр үзэгч урьдны ерөөлийн хүчинд шүтэж: цаст Төвдийн амьтан нугуудыг боловсрон гэтлэхүйд зохион: хязгаар хөшүүн орон энэ балар харанхуй дотор зул бадарсан мэт болон эрдэнийн тивд*” [35a19-21] үзсэн нь Нүдээр үзэгч бодьсадва өөрөө тэр газар орныг эцгийн ачийг хариулахын тулд шулмасын алж, “*Шулмасын нүгэлт цэцэрлэг*”-т хувилгасан тэр Хязгаар хөшүүн орныг дараах төрөлдөө Шударга төлгөн номын хаан болж ирээд, номхтгох их буяныг үйлдэх тайлал зохиол болсон мэт сэтгэгдэл төрж байна.

ГТО зохиолд Нүдээр үзэгч бодьсадва Хязгаар хөшүүн орныг хэрхэн номхтгосон тухай цадиг үлгэрүүд байдаг бөгөөд юуны учраас Хязгаар хөшүүн орон болсон тухай цадиг үлгэр нь ОЧХХ зохиол байж болох талаар өмнө дурдсан билээ. Энэхүү хоёр зохиолыг нэгтгэж байгаа зүйл нь зөвхөн дээрхи дүрслэл биш бөгөөд уг хоёр зохиолд гарч байгаа үг хэллэг, болоод уг хоёр зохиолын үйл явдлын баатар нь болох Оюу чихт хан хөвгүүн болон явж эцгийн ачийг хариулдаг бол нөгөө нь Шударга төлгөн хаан “*Хязгаар хөшүүн Цаст орон*”-ы номын хаан болсон тухай өгүүлдэг бөгөөд энэ нь Нүдээр үзэгчийн өмнөх болон хойт дүр юм. Тиймээс дээрхи хоёр зохиол нь нэг хүний ухаанаар бичигдсэн бүтээл байх магадлалыг илүү өндөр болгож байгаа юм. Тухайлбал, ОЧХХ зохиолд эрхэн Нүдээр үзэгчийн арав гаруй магтаал байгаа бөгөөд тэдгээр магтаалуудын утга агуулга нь ГТО зохиолын үг хэллэгтэй төсөөтэй байгаа юм. Тэдгээрээс дурдвал, *Наюуд тоот номын сан баригч ертөнцийн эрхт [ОЧХХ 23b28] найман түм дөрвөн мянган номын цогц [ГТ 19a25]; Онтогогүй усан шил эрх барьсанд оройгоор мөргөмүй. [ОЧХХ 28b2] гэснийг баруун дорд цагаан шэл эрх барин [ГТ 17a27]; Оюуны мянган гэрлийн нигүүлсэхүй сайтар төгссөн [ОЧХХ 28r26], Энэрэхүй нарны мянган гэрлээр гийгүүлэгч [ОЧХХ 46v4] гэснийг гэрэл хийгээд гэрэл арван зүгт цацрахуй нэгэн [ГТ 17b3]; Орчлонгийн дөрвөн далайн долгионоос гэтэлгэгч их онгоц чи [ОЧХХ 34a17] гэснийг Орчлонгоос гэтлэх онгоц сал мөн [ГТ 20b7]; Хэт ялгуусдын эрдэм нэгэнд хураасан мөн чанар [ОЧХХ 81b21] хамаг бурхдын хураангуй [19b31]* гэж дүрсэлсэн байгаагаас тодорхой ажиглаж болно.

Дээрхи хоёр зохиолын үйл явдлын хэлхээ холбоо, дүрслэлийн шинж байдал хийгээд хоёр зохиолын үг хэллэгийн тайлбар сэлт зэргийг үндэслээд баруун монголд анхлан дэлгэрсэн *Оюу чихт хан хөвгүүний тууж* зохиолыг Зая бандидын эцэс шавь хэлмэрч, хэлмэр Сойвон, Сойвон Сайн эрдэнэ хэмээн бичигт тэмдэглэгдсэн Раднаабадраа Энэтхэг Төвдийн ардын аман зохиолууд болон тухайн үед Монголын уран зохиолд хүчтэй түрэн орж байсан хойт эх-дагавар хүүхдийн сэдэвтэй зохиолын үндсэн санаанд тулгуурлан хутагт Нүдээр үзэгчийн хойд төрөлдөө Төвдийн орны эзэн болсон тухай цадиг түүхийн эргэх холбоо буюу тайлал болгон Түүний урд төрлийн цадиг үлгэрийг зохиосон байж магадгүй гэж үзэж байна.

RESUMÉ

THE TALE OF A PRINCE TURQUOISE-EARS.

(A literary comparison about authorship with *Gegeen toli orošiboi*)

This article is concerned with the question of authorship of a Mongolian literary text: *Oyōin čikitü xaān köböüni toūyiji orošibui* or *Ünekeēr törölkitü sayin xaāni toūji orošiboi*. (Eng. *The Tale of a Prince Turquoise-ears*) In order to investigate this issue, it is important to situate this text in the general context of the XVII-XVIII Buddhist literature after mass conversion in Mongolia.

The XVII-XVIII saw an emergence in the translation and composition of literary texts with Buddhist characters and motives that were inspired by religious texts from India and Tibet. With regards to *The Tale of a Prince Turquoise-ears* the question of the authorship can be state as follow: is the text an original composition or is it a translation of an Indian text?

In order to answer this question a literary comparison is made between this text and another other text, the *Gegeen toli orošiboi* edited by Ratnabadraa a disciple of Zaya bandita. The subsequent discussion about the author, the literary style of *Gegeen toli orošiboi* reveals similarities in style with the text under discussion, the *The Tale of a Prince Turquoise-ears*.

Ашигласан бүтээл:

1. *Gegeen toli orošiboi* (Тод үсгээр). УҮННСанд 8409/96 294.3. Г-897 дугаартай.
2. *Gegeen toli orošiboi* (Монгол бичгээр). УҮННСанд 8434/96 294. Г-897 дугаартай.
3. Заябандида, Равжамба. *Сарны гэрэл оривой*. Улаанбаатар. 1967.
4. *Oyū čikitü xaān köböüni toūji orošiboi* (Тод үсгээр). ХИС-ын МХУЗ-ын тэнхмийн харьяа “Монголчуудын бичиг үсгийн дурсгалын сан”-д Тоб №95.
5. *Оюу чихт хан хөвгүүний тууж тэргүүтэн монголын сонгодог уран зохиолын хэдэн дурсгал*. Эрхэлсэн Д. Ганболд, 2005.
6. Rabjamba Say-a bandita-yin tuūji saran-u gerel kemekü ene metü bolai /Монгол бичгээр/. CSM. T-V, Fasc.2. Улаанбаатар. 1959.
7. *Ünekeēr törölkitü sayin xaāni toūji orušibui*. /Тод үсгээр./ УҮННСангийн тод үсгийн сан хөмрөгт 8308/96 401 дугаартай.
8. *Üneker törülkitü sayin qaγan-u tuūji orušibui*. /Монгол бичгээр./ УҮННСангийн монгол бичгийн сан хөмрөгт 7963/96 89 v-856 дугаартай.
9. Хүрэлбаатар, Л. “XV-XVI зууны үеийн орчуулгын зохиол” *Монгол орчуулгын товчоон (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудал)*. Улаанбаатар хот. 1995.; *Тод бичиг болон Зая бандида Намхайжамц судлалын асуудал Bibliotheca Oiratica-XIII*. Улаанбаатар. 2009.
10. Цэрэнсодном, Д. “XVII-XVIII зууны үеийн уран зохиол” *Монголын уран зохиолы судлалын шинэ хандлага*. Улаанбаатар. 2008.
11. http://mn.wikipedia.org/wiki/Тогоонтөмөр_хаан